



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагааннуур тосгоны ЕБ-ын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/104/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954

Цахим хаяг: Khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930

Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: К.Риза

Утас: 94156768

Цахим хаяг: Kalim_riza@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	16
.....	
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ЦАГААННУУР ТОСГОНЫ ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ К.ГҮЛЖАН ТАНАА

᠒᠐᠒᠒.᠐᠗.15 № 48
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>30745667.08</u>	<u>43512878.41</u>
33	АВЛАГА	744831.00	96349.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	744831.00	96349.00
35	БАРАА МАТЕРИАЛ	30000836.08	43416529.41
351	Түүхий эд материал	11623056.81	12481618.89
35110	Тусгай зориулалттай материал	11623056.81	12481618.89
354	Хангамжийн материал	18377779.27	30934910.52
35410	Бичиг хэргийн материал	2060511.07	2174561.07
35420	Аж ахуйн материал	11433377.00	21896803.00
35460	Хүнсний материал	47431.20	2033086.45
35470	Бусад хангамжийн материал	4836460.00	4830460.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2592276546.25</u>	<u>2586154134.78</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2592276546.25	2586154134.78
392	Биет хөрөнгө	2553156146.25	2547033734.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	2566272328.00	2566272328.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-65405650.63	-116301514.51
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	75465910.90	83246965.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-55172255.14	-57595979.81
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40294581.65	71609459.48
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30754589.10	-33847399.41
39214	Бусад үндсэн хөрөнгө	2434572.00	10000000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2434572.00	-333333.32
39217	Ном	22455820.57	23983208.45
393	Биет бус хөрөнгө	39120400.00	39120400.00
39301	Програм хангамж	550000.00	550000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000.00	-550000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	39120400.00	39120400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	<u>2623022213.33</u>	<u>2629667013.19</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>3912000.00</u>	<u>0.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3912000.00	0.00
413	Өглөг	3912000.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2619110213.33</u>	<u>2629667013.19</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2619110213.33	2629667013.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	272770780.68	272770780.68
51101	Өмч: - төрийн	272770780.68	272770780.68
512	Хуримтлагдсан үр дүн	1848455704.65	1859012504.51
51210	Өмнөх үеийн үр дүн	1848455704.65	1848455704.65
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	10556799.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	497883728.00	497883728.00

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2623022213.33</u>	<u>2629667013.19</u>
---	--	-----------------------------	-----------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,898,164,892.81	749,238,128.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	548,529,221.81	11,299,156.08
120	Нийтлэг татварын бус орлого	1,497,221.81	11,299,156.08
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,497,221.81	11,299,156.08
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,497,221.81	11,299,156.08
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,349,635,671.00	737,938,972.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,300,063,539.00	658,267,145.71
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	2,300,063,539.00	58,457,645.71
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	547,032,000.00	599,809,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	467,427.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	467,427.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,572,132.00	79,204,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,572,132.00	79,204,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	632,846,925.35	738,681,328.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	632,846,925.35	738,681,328.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	598,619,575.35	717,313,751.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	434,622,657.00	488,685,500.00
210101	Үндсэн цалин	367,744,057.00	425,387,800.00
210102	Нэмэгдэл	-	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	48,727,400.00	31,533,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,151,200.00	31,764,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,217,600.00	66,171,600.00
210201	Тэтгэврийн даатгал	40,968,000.00	46,565,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,312,400.00	4,901,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,449,900.00	3,921,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	862,500.00	980,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,624,800.00	9,803,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,682,732.00	75,431,095.00
210301	Гэрэл, цахилгаан	1,594,262.00	2,404,209.00
210302	Түлш, халаалт	50,110,600.00	71,791,415.00
210303	Цэвэр, бохир ус	1,977,870.00	1,235,471.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,337,550.00	6,188,416.00

210401	Бичиг хэрэг	913,950.00	1,393,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,064,800.00	3,048,727.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	616,800.00	493,800.00
210404	Ном, хэвлэл	24,000.00	110,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	718,000.00	1,141,989.00
2105	Нормативт зардал	7,556,258.56	12,372,833.75
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	133,860.00	250,500.00
210502	Хоол, хүнс	6,205,498.56	10,478,823.75
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,216,900.00	1,643,510.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-
2107	Томилолт, зочны зардал	182,000.00	196,000.00
210702	Дотоод албан томилолт	182,000.00	196,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	560,000.00	570,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,000.00	70,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,460,777.79	67,698,307.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	726,000.00	1,608,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,734,777.79	66,090,057.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,227,350.00	21,367,577.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,000,200.00	19,249,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,000,200.00	19,249,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,227,150.00	2,118,077.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,227,150.00	2,118,077.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2,265,317,967.46</u>	<u>10,556,799.86</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>2,265,317,967.46</u>	<u>10,556,799.86</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	233,650,380.68	335,604,096.00	-56,909,337.67	512,345,139.01
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	1,894,418.00	1,894,418.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	233,650,380.68	335,604,096.00	-55,014,919.67	514,239,557.01
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	-1,894,418.00	0.00	-1,894,418.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-30,694,876.48	-30,694,876.48

C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	272,770,780.68	497,883,728.00	1,848,455,704.65	2,619,110,213.33
D01	2020 оны 12 р сарын 31-нээрх үлдэгдэл	272,770,780.68	497,883,728.00	1,848,455,704.65	2,619,110,213.33
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	272,770,780.68	497,883,728.00	1,848,455,704.65	2,619,110,213.33
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	10,556,799.86	10,556,799.86
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	272,770,780.68	497,883,728.00	1,859,012,504.51	2,629,667,013.19

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	596604132.00	679481327.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	49572132.00	679481327.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	599809500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	547032000.00	599809500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	467427.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		467427.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49572132.00	79204400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49572132.00	79204400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	591904132.00	677971327.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	591904132.00	677971327.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	557676782.00	656603750.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	432241000.00	488261323.00
210101	Үндсэн цалин	365362400.00	424963623.00
210104	Урамшуулал	48727400.00	31533200.00
210105	Гэрээт ажлын хөлс	18151200.00	31764500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58217600.00	66171600.00
210201	Тэтгэврийн даатгал	40968000.00	46565300.00
210202	Тэтгэмжийн даатгал	4312400.00	4901500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3449900.00	3921300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	862500.00	980300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8624800.00	9803200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49572132.00	79204400.00
210301	Гэрэл, цахилгаан	1594262.00	2054000.00
210302	Түлш, халаалт	46000000.00	75900450.00
210303	Цэвэр, бохир ус	1977870.00	1249950.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4892000.00	5137727.00
210401	Бичиг хэрэг	523500.00	172000.00
210402	Тээвэр, шатахуун	2064800.00	3048727.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	741000.00	902800.00
210404	Ном, хэвлэл	342800.00	245600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1219900.00	768600.00
2105	Нормативт зардал	10176150.00	14884600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	108600.00	111300.00
210502	Хоол, хүнс	5800350.00	14037200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4267200.00	736100.00
2107	Томилолт, зочны зардал	182000.00	196000.00
210702	Дотоод албан томилолт	182000.00	196000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	560000.00	745600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60000.00	245600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500000.00	500000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1835900.00	2002500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1835900.00	2002500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34227350.00	21367577.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7000200.00	19249500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7000200.00	19249500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27227150.00	2118077.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27227150.00	2118077.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4700000.00</u>	<u>1510000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>4700000.00</u>	<u>1510000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>4700000.00</u>	<u>1510000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>4700000.00</u>	<u>1510000.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4700000.00	1510000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-4700000.00</u>	<u>-1510000.00</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	607339900.00	569376982.00	680872500.00	677363250.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	607339900.00	569376982.00	680872500.00	677363250.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	599716400.00	562376782.00	661404500.00	658113750.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	432241000.00	432241000.00	490160400.00	488261323.00
210101	Үндсэн цалин	365362400.00	365362400.00	426862700.00	424963623.00
210104	Урамшуулал	48727400.00	48727400.00	31533200.00	31533200.00
210105	Гэрээт ажлын хөлс	18151200.00	18151200.00	31764500.00	31764500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58217600.00	58217600.00	66171600.00	66171600.00
210201	Тэтгэврийн даатгал	40968000.00	40968000.00	46565300.00	46565300.00

210202	Тэтгэмжийн даатгал	4312400.00	4312400.00	4901500.00	4901500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3449900.00	3449900.00	3921300.00	3921300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	862500.00	862500.00	980300.00	980300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8624800.00	8624800.00	9803200.00	9803200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54419300.00	49572132.00	80563000.00	79204400.00
210301	Гэрэл, цахилгаан	2377200.00	1594262.00	2377000.00	2054000.00
210302	Түлш, халаалт	49912000.00	46000000.00	76556000.00	75900450.00
210303	Цэвэр, бохир ус	2130100.00	1977870.00	1630000.00	1249950.00
210304	Байрны түрээс				
2104	Хангамж, бараа материалын зардал	14727500.00	7392000.00	4670300.00	5137727.00
210401	Бичиг хэрэг	523500.00	523500.00	172000.00	172000.00
210402	Тээвэр, шатахуун	2581300.00	2064800.00	2581300.00	3048727.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	890000.00	741000.00	902800.00	902800.00
210404	Ном, хэвлэл	380800.00	342800.00	245600.00	245600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн үстгал, ариутгал	132000.00			
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10219900.00	3719900.00	768600.00	768600.00
2105	Нормативт зардал	27026900.00	12376150.00	16194600.00	16194600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	144600.00	108600.00	111300.00	111300.00
210502	Хоол, хүнс	10443100.00	6800350.00	15347200.00	15347200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16439200.00	5467200.00	736100.00	736100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	0.00	500000.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл				
2107	Томилолт, зочны зардал	713900.00	182000.00	196500.00	196000.00
210702	Дотоод албан томилолт	713900.00	182000.00	196500.00	196000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	880800.00	560000.00	745600.00	745600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	380800.00	60000.00	245600.00	245600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11489400.00	1835900.00	2202500.00	2202500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11489400.00	1835900.00	2202500.00	2202500.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7623500.00	7000200.00	19468000.00	19249500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7623500.00	7000200.00	19468000.00	19249500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7623500.0	7000200.0	19468000.00	19249500.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	607339900.00	569376982.00	680872500.00	676895823.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	552920600.00	519804850.00	599809500.00	597691423.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	552920600.0	519804850.0	599809500.00	597691423.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	54419300.00	49572132.00	81063000.00	79204400.00
132001	Орон нутгийн төсвөөс	54419300.0	49572132.0	81063000.00	79204400.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42.00	44.00	50.00	50.00
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	23.0	22.0	22.00	22.00
620003	Үйлчлэх ажилтан	14.0	17.0	17.00	17.00
620004	Гэрээт ажилтан	4.0	4.0	10.00	10.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	467427.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	467427.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	467427.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	467427.00	
210402	Тээвэр, шатахуун		467427.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл, гэрээт аудитор К.Риза нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн №03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн эрхэм зорилго нь “Суралцагчдын хэрэгцээнд суурилсан хүртээмжтэй, сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан зөв хандлага төлөвшилтэй, бүтээлч, бие даан сурах хүсэл тэмүүлэлтэй хүүхдүүдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмшүүлэх бэлтгэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд тус сургуулийн үйл ажиллагаанд шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 632.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 12.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.3 сая төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	744,8	96,3	(648,5)
Бараа материал	30000,8	43416,5	13415,7
Үндсэн хөрөнгө	2592276,5	2586154,1	(6122.4)
Нийт хөрөнгө	2623022,2	2629667,0	6644.8
Өр төлбөр	3912,0		(3912.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2619110,2	2629667,0	(10556.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2623022,2	2629667,0	6644.8

Мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй байна. Авлага дансны үлдэгдэл өнгөрсөн оноос 0.7 сая төгрөгөөр буурч НДШ, ХХОАТатвартай холбоотой авлагатай гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл оны эхнээс 13.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 43.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Боловсролын яамнаас 0.9 сая төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн, Аймгийн Боловсролын газраас “СТЕМ” хөтөлбөрийн хүрээнд 0.9 сая төгрөгийн хэрэглэгдэхүүн олгосон мөн ОНХСангийн хөрөнгөөр 9.5 сая төгрөгийн зөөлөн эдлэл бэлтгэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1.5 сая төгрөгийн бичиг хэрэг, 4.0 сая төгрөгийн аж ахуйн материал, 12.4 сая төгрөгийн хүнсний материал, 0.2 сая төгрөгийн эм боох материал, нийтдээ 18.2 сая төгрөгийн бараа материалыг худалдан авсан ба 11.3 сая төгрөгийн аж ахуйн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээж авч нийтдээ 29.5 сая төгрөгийн бараа материалыг орлогод авч, 16.1 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зохих зарлагын баримтуудыг үндэслэн зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхнээс 6.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 1.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсан, БШУЯамнаас 46.9 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж үнэ төлбөргүй олгосон, ОНХСангийн хөрөнгөөр 10.0 сая төгрөгийн сургуулийн гадна талын хашаа барьж ашиглалтад оруулан №БӨАОНӨГ/20211019 гэрээний дагуу хүлээлгэн өгсөнийг бусад үндсэн хөрөнгө дансанд бүртгэж орлогод авсан, тайлант онд ашиглалтын хугацаа дуусаж ашиглах боломжгүй болсон 11.8 сая төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг Аймгийн ИТХ-ын

Тэргүүлэгчдийн 2021 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 01 тоот тогтоолоор ашиглалтаас хасаж, устгалтын комиссын актын дагуу акталж устгасан мөн тайлант онд байгуулсан элэгдлийн зардлын дүнгийн зөрүүгээр буурсан дүнтэй байна.

Аймгийн Санхүү, Төрийн Сангийн хэлтсийн зөвшөөрсний дагуу хоолны зардлын хэмнэлтийг хичээл практик, нормын хувцас зөөлөн эдлэл бэлтгэх зардалд гүйлгэн зарцуулж, 1.5 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, 1.3 сая төгрөгөөр аж ахуйн зүйл худалдан авсан байна.

Оны эхэнд 3.9 сая төгрөгийн НДШ-ийн өртэй байсныг тайлант онд бүрэн барагдуулж оны эцэст өр төлбөр гараагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2149.0 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгийн санхүүжилт буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 105.9 сая төгрөгөөр буюу 16.7 хувиар өссөн нь шинэ хичээлийн байр ашиглалтад орсонтой холбоотойгоор 2 үйлчлэгч, 4 галч нэмж авч ажиллуулан цалин, НДШ-ийн зардал 62.1 сая төгрөгөөр, түлш халаалтын зардал 21.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, нормативт зардал 4.8 сая төгрөгөөр, үдийн хоол өгөхтэй холбоотойгоор үдийн цайны зардал урьд оноос 13.3 сая төгрөгөөр өссөн зэрэг нь нөлөөлжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд санхүүжилтийн орлогыг 742.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 742.1 сая төгрөгөөр тооцон төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны 16 дугаар тогтоолоор сургуулийн 2020 оны төсвийг төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 115.9 сая төгрөгөөр бууруулан 626.2 сая төгрөгөөр баталжээ.

Нийт төсвийн 565.5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 77.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны 41 дүгээр тогтоолоор баталсан төсвийн тодотголоор цалин, НДШ-ийн зардлыг 47.1 сая төгрөгөөр нэмж, нормативт зардлыг 9.0 сая төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлын төсвийг 7.5 сая төгрөгөөр, халаалтын зардлыг 3.0 сая төгрөгөөр бууруулж тодотгон тусгай зориулалтын дэмжлэгээс авах санхүүжилтийн хэмжээг 27.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт төсвийг 680.8 сая төгрөгөөр баталсан байна.

Анх баталсан болон тодотгосон төсөвт орон тооны хязгаарыг 50 хүнээр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 597.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 79.2 сая төгрөгийн нийтдээ 676.9 сая төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж батлагдсан төсвийг 2.1 сая төгрөгөөр хэмнэж хэмнэлтийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 674.8 сая төгрөг буюу 99.6 хувьтай байна.

Нийт төсвийн 82.2 хувийг цалин, НДШ-ийн зардал, 11.2 хувийг тогтмол зардал, 1.8 хувийг хангамж бараа материалын зардал, 2.0 хувийг норматив зардал, 2.8 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаа явуулж оны эцэст хэмнэлт болох 2.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.

Тус сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн горим сорилын дүнгээр үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлуудад цалингийн зардалд 488.8 сая төгрөг, НДШ-ийн зардалд 66.2 сая төгрөг, халаалтын зардалд 71.8 сая төгрөг, хүүхдийн хоолны зардалд 12.4 сая төгрөг, үдийн цайны зардалд 19.2 сая төгрөг нийтдээ 658.6 сая төгрөг зарцуулсан байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд Аймгийн Боловсролын газраас тээврийн хөлст зориулан 467.4 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтээр олгосныг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайландаа тусгажээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

Байгууллагын сургалтын үйл ажиллагаа ковидтой холбоотойгоор танхимаар болон цахимаар явагдаж ирсэн ба байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Тус сургуулийн нийт санхүүжилт 676.9 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай 658.6 сая төгрөгийн зардлыг хасаж 18.3 сая төгрөгийг тэвчиж болох зардал гэж үзээд 1.8 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байна. Сургууль нь оны эцэст 2.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн тул Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласан байна гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал 668,1 сая төгрөгийн 148 мэдээллээс 668,1 сая төгрөгийн 147 мэдээллийг хугацаандаа байршуулж, 2020 оны санхүүгийн тайлан, дүгнэлтийг 1 мэдээллийг хугацаа хожимдуулан байршуулсан байна.

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй 69.3 сая төгрөгийн 4 удаагийн гүйлгээг байршуулсан байна.

Цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогод санхүүжилтийн 668.1 сая төгрөгийн 12 удаагийн мэдээллийг байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 147 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулан мэдээлэл оруулсан байдлын хэрэгжилтийн хувь 99.3 хувьтай, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасан байдаг.

Тайлант оны орлого, зарлагын гүйлгээ хууль журмын дагуу хийгдсэн эсэхийг шалгаж үзэхэд баримтын бүрдэлтийг хуульд заасны дагуу бүрдүүлж орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой 1 зөвлөмж, 0.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдсөн ба зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг хугацаандаа ирүүлжээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар шилэн дансанд 1 мэдээллийг хугацаа хожимдуулан байршуулснаас бусад алдаа зөрчил илрээгүй болно.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа гараагүй болно.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн